



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/ИИ


Улаанбаатар хот

┌ Багш нарын баярын 54 дэх өдрийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн багш нарын баярын 26, Монголын багш нарын 54 дэх өдрийг дүүрэгт 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.
2. Дэлхийн багш нарын баярын 26, Монголын багш нарын 54 дэх өдрийг дүүрэгт тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийг нэгдүгээр, зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж үр дүнг эргэн тайлагнахыг Ажлын хэсэг /Ш.Баасансүрэн/-т үүрэг болгосугай.
4. Арга хэмжээнд зарцуулагдах 513.000 /Таван зуун арван гурван мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч /С.Баасанхүү/-д зөвшөөрсүгэй.
5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Б.Болормаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА *С. Эрдэнэбаяр* ЭРДЭНЭБАЯР



АЖИЛ 2020 он ажил захирамж

1123020559

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2020 оны 09 сарын 15 -ны өдрийн 11111 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

БАГШ НАРЫН БАЯРЫН 54 ДЭХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Боловсролын хэлтсийн дарга

Гишүүд: “Хангай” цогцолбор сургуулийн захирал

44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

183 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсрол, соёл урлагийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга Боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн

